

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 111

Сүмбэр сум

Хүүхэд бидний хөгжил, оролцоо  
сарын аянд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенцийн 12,14 дүгээр заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.1.3, 6.1.5 дэх заалт, “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.2, 2.2.3, 2.2.4 дүгээр зорилт, 2021 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтын 9.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан “Хүүхэд бидний хөгжил, оролцоо” сарын аяны удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тус сарын аяны үйл ажиллагааг чанартай зохион байгуулж үр дүнг тайлагнан ажиллахыг Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн (Э.Урантунгалаг)-д даалгасугай.


3. Сарын аяны үйл ажиллагаанд зарцуулагдах 560.000 (таван зуун жаран мянга) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНБИЛЭГ



ГБХЗХГазрын даргын 2021 оны  
02 сарын 15-ний өдрийн  
дугаар тушаалын 7-р хавсралт



### “ХҮҮХЭД БИДНИЙ ХӨГЖИЛ-ОРОЛЦОО” САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

#### НЭГ. Үндэслэл

Цар тахал дэлхийн улс орнуудад дэгдсэнтэй холбогдуулан улс орон даяар бүх шатны сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоон хорио цээрийн дэглэмтэй байгаа энэ үед хүүхэд багачуудын хөгжлийг дэмжих, эцэг эхчүүдийн хүүхэддээ зарцуулах цагийг үр дүнтэй болгон нэмэгдүүлэх, хамтдаа бүтээж хөгжихөд дэмжлэг үзүүлэх зорилгоор “ХҮҮХЭД БИДНИЙ ХӨГЖИЛ-ОРОЛЦОО” сарын аяныг 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 02 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулна.

#### ХОЁР. Зорилго

Хүүхдийг хөгжүүлж оролцуулах эцэг эх, хүүхдийн хамтын ажиллагааг сайжруулах, хүүхдийн бие даан хөгжих боломжийг дэмжих, танин мэдэхүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлнэ.

#### ГУРАВ. Хугацаа

2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 02 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл

#### ДӨРӨВ. Хамрах хүрээ

- 1-3 дугаар анги
- 4-6 дугаар анги
- 7-9 дүгээр анги
- 10-12 дугаар анги

#### ТАВ. Зохион байгуулах ажил

№	Насны ангилал	Хийгдэх ажил	Тайлбар	Хугацаа
1	1-3 дугаар анги	“Монгол ардын үлгэр” ярих	Монгол ардын үлгэр уншиж, эсвэл эцэг эх нь ярьж өгсөн үлгэрийг сонсож өөрийн ойлгож мэдсэнээ бусдад ярьж өгнө. Эцэг эх нь хүүхдийнхээ үлгэр ярьж байгаа бичлэгийг 3-5 мин багтааж, дуу дүрсийг чанартай хийж Говьсүмбэр аймгийн гбхзхг гэсэн фб хаягаар ирүүлнэ.	2021.01.08-2021.02.05-ны өдөр хүртэлх хугацаанд авна.

2		“Сайхан бичиг” бичих	Эцэг эх нь өөрийнхөө мөн хүүхдийнхээ Эхийг цэвэр, сайхан бичсэн бүтээлийг <b>Говьсүмбэр аймгийн гбхзхг</b> гэсэн фб хаягаар ирүүлнэ. /Цаасан хэлбэрээр ирүүлж болно./	
7	4-6 дугаар анги	“Сургамжит өгүүллэг уншиж, тайлбарлан ярих”	Сургамжит өгүүллэг уншин өөрийн ойлгож мэдсэнээ ярина. Эцэг эх нь хүүхдийнхээ өгүүллэг ярьж байгаа бичлэгийг 3-5 минутанд багтааж, дуу дүрсийг чанартай хийж <b>Говьсүмбэр аймгийн гбхзхг</b> гэсэн фб хаягаар ирүүлнэ.	2021.01.08-2021.02.05-ны өдөр хүртэлх хугацаанд авна.
9		“Гэрийн дүрэм” эцэг эхтэйгээ хамтран гүйцэтгэнэ. /2 минут/	Эцэг эхтэйгээ хамтран гэрийн дүрэм боловсруулж, түүнийгээ танилцуулсан, хэрхэн мөрдөж байгааг тайлбарласан бичлэг хийж <b>Говьсүмбэр аймгийн гбхзхг</b> гэсэн фб хаягаар ирүүлнэ. /Цаасан хэлбэрээр ирүүлж болно./	
10	7-9 дүгээр анги	Гарын доорхи материал ашиглан <b>Бүтээл урлаарай.</b>	Эцэг эхтэйгээ хамтран гарын доорх материал ашиглан хүнд хэрэгтэй бүтээл хийж <b>Говьсүмбэр аймгийн гбхзхг</b> гэсэн фб хаягаар ирүүлэх.	2021.01.08-2021.02.05-ны өдөр хүртэлх хугацаанд авна.
11		Уран зохиол уншиж судлах	7-9-р ангид заавал уншиж судлах уран зохиол уншиж тэмдэглэл хөтлөн ярина. Эцэг эх нь хүүхдийнхээ уран зохиолын утга санааг ярьж байгаа бичлэгийг 3-5 минутанд багтааж, дуу дүрсийг чанартай хийж <b>Говьсүмбэр аймгийн гбхзхг</b> гэсэн фб хаягаар ирүүлнэ.	
13	10-12 дугаар анги	<b>Монгол бичгээр эхийг хичээнгүй бичих</b>	Эцэг эхтэйгээ хамтран А4 цаасан дээр эхийг монгол бичгээр цэвэр сайхан бичиж <b>Говьсүмбэр аймгийн гбхзхг</b> гэсэн фб хаягаар ирүүлнэ. /Цаасан хэлбэрээр ирүүлж болно./	2021.01.08-2021.02.05-ны өдөр хүртэлх хугацаанд авна.
14		<b>Дэлхийн сонгодог зохиол унших</b>	Дэлхийн сонгодог зохиол уншиж, тэмдэглэл хөтлөн подкаст танилцуулга хийсэн бичлэгээ 3-5 минутанд багтааж, дуу дүрсийг чанартай хийж <b>Говьсүмбэр аймгийн гбхзхг</b> гэсэн фб хаягаар ирүүлнэ.	

### ЗУРГАА. Шалгаруулалт, шалгуур үзүүлэлт

Энэхүү цахим уралдаанд оролцож байгаа хүүхдүүдийг дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан эхний 3 байрыг эзлүүлнэ.

1. Оролцогч өөрийн оролцож буй насны ангилалд зохион байгуулсан 2 төрлийн үйл ажиллагаанд бүрэн хамрагдсан байна.
2. Ирүүлсэн материалдаа холбоо барих утасны дугаар, сургууль, анги гэх мэт мэдээллийг бүрэн бичсэн байна.

3. Хугацаа хоцорсон материал ирүүлсэн тохиолдолд оноо хасна, бүтээлийг дуу дүрсний чанартай хийж ирүүлсэн байна.

**ДОЛОО. Шагнал, урамшуулал**

Ангилал тус бүрт


1 байр- Өргөмжлөл, дурсгалын зүйл

2 байр- Өргөмжлөл, дурсгалын зүйл

3 байр- Өргөмжлөл, дурсгалын зүйл

Тусгай байр- Өргөмжлөл, дурсгалын зүйлээр урамшуулна.

ГБХЗХГазрын даргын 2021 оны  
02 сарын 15-ний өдрийн  
дугаар тушаалын 2-р хавсралт



**ХҮҮХЭД БИДНИЙ ХӨГЖИЛ-ОРОЛЦОО” САРЫН АЯНЫ ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Шир хэг	Нэг бүрийн үнэ	Нийт зардал
<b>Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар</b>				
1	1 байр Мөнгөн шагнал	4	50.000	200.000
2	2 байр Мөнгөн шагнал	4	40.000	160.000
3	3 байр Мөнгөн шагнал	4	30.000	120.000
4	Тусгай байр- Мөнгөн шагнал	4	20.000	80.000
<b>Нийт</b>				<b>560.000</b>
<b>Дэлхийн зөн ОУБ Бор-Өндөр1 ОНХ</b>				
5	Өргөмжлөл	16	5.000	80.000
6	Хичээлийн хэрэгсэл <ul style="list-style-type: none"> <li>➤ Дэвтэр-2500</li> <li>➤ Үзгэн бал-хайрцаг 6000</li> <li>➤ Дотруулагч-2000</li> <li>➤ Өнгийн харандаа-3500</li> <li>➤ Гортиг-4500</li> <li>➤ Штрик-1500</li> </ul>	16	20.000	320.000
7	Хүүхдийн ном /Уран зохиол- Гүйж яваа эмэгтэй, Малала, ухаан далай номоос ихтэй, Дэлхийн хүүхдийн сонгодог зохиолууд/ ном/	16	20.000	320.000
<b>Нийт</b>				<b>720.000</b>
<b>Нийт</b>				<b>1.280.000</b>